

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ХҮНИЙ НӨӨЦ, ЁС ЗҮЙ ДОТООД АЖИЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ШАРААГИЙН УНДАРМААГИЙН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
	1	2	3	4	5		6	7
Зорилт 1. “Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд”								
1.	Арга хэмжээ 1.1. “Албан хаагчдын сургалтын хөтөлбөр”, “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг хангах	Хувь	95.0	100%	-Нийслэлийн Аялал жуулчлалын газрын албан хаагчдын 2024 оны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. 1.Нийт 57 удаагийн сургалтад давхардсан тоогоор 239 албан хаагч хамрагдлаа. /эмэгтэй 160, эрэгтэй 79/ Үүнээс албан хаагчдыг мэргэшүүлэх, мэдлэг чадварыг хөгжүүлэх, сайжруулах зорилгоор Засгийн газрын зорилтод 2 удаагийн сургалтад 3 албан хаагч, Төрийн албаны зөвлөлөөс зохион		01-12-р сар	100%

					байгуулсан 7:4:10 сургалтад 16 удаа, давхардсан тоогоор 144 албан хаагч, Удирдлагын академийн богино хугацааны 5 удаагийн сургалтад 10, Төрийн албанд анх томилогдсоны дараах сургалтад 1, бусад 33 удаагийн сургалтад давхардсан тоогоор 81 албан хаагч хамрагдлаа. -Худалдан авах ажиллагааны хөтөч сургалтын төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, 4 удаагийн сургалтаар 18 албан хаагчийг хамруулж, 5 албан хаагч гэрчилгээтэй болоод байна. Мөн нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулсан 3 удаагийн сургалтад 4 албан хаагч хамрагдсан. 2.Нийт 8 удаагийн хэлэлцүүлэг, зөвлөгөөн, хөтөлбөрт давхардсан тоогоор 36 албан хаагч хамрагдсан. Нийслэлийн Засаг даргын нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчидтай хийх уулзалтад 15, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан хэлэлцүүлэгт 8, төрийн ордонд зохион байгуулагдсан "Youth mongolia" залуучуудын хөгжлийн зөвлөлийн анхдугаар чуулганд байгууллагын залуучуудын зөвлөлийн 2 гишүүн, Төрийн албан хаагчийн хөгжил хамгаалал хэлэлцүүлэгт 4, Бүсүүдийн хөгжлийн үндэсний чуулганд 3, Менторшин хөтөлбөрт 1, нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн	
--	--	--	--	--	--	--

				сан байгуулах уулзалт хэлэлцүүлэгт 1 хаагч хамрагдлаа. Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийн хэлэлцүүлэгт 2 албан хаагч хамрагдлаа. 3. 2024 оны 05 дугаар сарын 08-13-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос улсын Сөүл хотноо зохион байгуулсан “Сөүлийн олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн”, 2024 оны 04 дүгээр сарын 22-28-ны өдрүүдэд БНХАУ-д болсон Монгол улс, Улаанбаатар хотыг сурталчлах “B2C” арга хэмжээ, 2024 оны 07 дугаар сарын 04-17-нд Тайваньд болсон “Эко аялал жуулчлал” сургалт семинар, 2024 оны 09 дүгээр 26-29-ны өдрүүдэд Япон улсын Токио хотод болсон олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд тус бүр 1, нийт 4 албан албан хаагч оролцож, туршлага судалсан. 4. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод журмын хүрээнд албан хаагчдад цалин, урамшуулал, ээлжийн амралт, илүү цагийн олговрыг тухай бүр олгож байна. Ёс зүйн дэд хорооны 3 гишүүнд урамшуулал олгож, 3 албан хаагчид ээлжийн амралтыг хэсэгчлэн, 12 албан хаагчид ээлжийн амралтыг биеэр эдлүүлж, давхардсан тоогоор 38 албан хаагчид илүү цагийн	
--	--	--	--	---	--

					нөхөн олговрыг олгосон. 2024 оны 06 дугаар сараас албан хаагчдын хоол, унааны мөнгө өдрийн 35,000 төгрөг болон нэмэгдээд байна. 5.Хүний нөөцийн нэгдсэн систем https://hrm.csc.gov.mn/-ийг үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж, албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээллийг тогтмол шинэчлэн, албан хаагчдын олон талт судалгааг шинэчилж, 4 албан хаагчид зэрэг дэвийн нэмэгдэл, 1 албан хаагчийн төрийн албаны тангарагыг өргүүлсэн. 6.Байгууллагын албан хаагчдын шагналын судалгааг шинэчилж, өндөр насны тэтгэвэрт гарсан 1 албан хаагчийг "Алтан гадас" одон болон "Төрийн албаны тэргүүний ажилтан" цол тэмдгээр шагнуулсан. Мөн Аялал жуулчлалын өдөр, нийслэлийн өдрийг тохиолдуулан 1 албан хаагч Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Тэргүүний ажилтнаар, 1 албан хаагч Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Жуух бичгээр, 2 албан хаагч Нийслэлийн Тэргүүний ажилтнаар, 1 албан хаагч НИТХ-ын Хүндэт үнэмлэхээр шагнагдсан. 7.Албан хаагчдын ажлын ачаалалтай уялдуулан долоо хоногийн 1 өдөр цахимаар ажиллуулж, нийслэлийн Худалдан авах ажиллагааны газартай		
--	--	--	--	--	--	--	--

				хамтран Хан-Уул дүүргийн 34 дүгээр сургуулийн спорт заалыг түрээсэлж, албан хаагчдыг спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлсэн. 8.Нийслэлийн Аялал жуулчлалын газрыг Хан-Уул дүүргийн 23 дугаар хороонд байрлах нутгийн захиргааны цогцолбор байр руу нүүлгэх ажлыг нийслэлийн Цэргийн штабтай хамтран 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулж, нүүлгэх зардлыг Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсээр шийдвэрлүүлсэн. Хан-Уул дүүргийн 23 дугаар хороонд байрлах нутгийн захиргааны цогцолбор байрны Б блок барилгад нүүж ирсэнтэй холбогдуулан албан хэрэгцээнд 15 ширхэг иж бүрэн компьютер, 2 принтер, 10 ширхэг утасны аппараттыг шинээр олгуулж, 3 өрөөнд хөшиг суурьлуулж, байгууллагын гадна болон доторх хаягийг хэвлүүлэн байрлуулж, албан хаагчдын ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн. 9.АШУУИС-ийн Монгол-Японы эмнэлэгтэй хамтран 10 албан хаагчийг эрүүл мэндийн багц үзлэг шинжилгээнд хамруулахад 2,654,000 төгрөг, Олон улсын "Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тохиолдуулан албан хаагчдын 36 хүүхдэд хүндэтгэл үзүүлж, 2,916,360 төгрөг, 1 албан хаагчийн "Алтан гадас"	
--	--	--	--	--	--

					одонгийн мөнгөн шагналд 300.000 төгрөг нийт 5,870,360 төгрөгийг зарцуулсан. 10.Нийслэлийн орон сууцны хөтөлбөрт хамрагдах судалгааг албан хаагчдаас авч, 11 албан хаагчийн саналыг нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Мөн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгаагаар хангах ажлыг бодитой болгохын тулд орон сууцны дэмжлэг үзүүлэх төсвийг тухайн байгууллагын төсөвт давтамжтайгаар суулгах саналыг нийслэл дэх Төрийн аудитын газрын "Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө" гүйцэтгэлийн аудитын дүгнэлтэд гаргаж өгсөн. Нийт 17 албан хаагч ажиллаж байгаагаас түрээсийн орон сууцанд гурав, аав ээжийндээ 2, гэр хороололд 2 албан хаагч амьдарч байгаа бол 5 албан хаагч орон сууцны зээлэнд хамрагдаад байна. 1 албан хаагч орон сууцны санхүүжилтийн дэмжлэг хүссэн албан хүсэлтийг нийслэлийн Засаг даргын Тамгын газарт өгөөд байна.		
2.	Арга хэмжээ 1.2. Хүний нөөцийн ил тод байдлыг ханган сул орон тоог нөхөх ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах	Хувь	Тухай бүрт	100%	-Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд төрийн жинхэнэ албан хаагчийн удирдах 1 албан тушаал, гүйцэтгэх 1 албан тушаал нийт 2 албан тушаалын сул орон тоог нөхөх захиалгыг хүргүүлж Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлэн сонгон шалгаруулалтыг зохион	01-06-р сар	100%

					байгуулж, нэр дэвшүүлсэн албан хаагчдаас сул орон тоог нөхөх ажлыг зохион байгуулсан.		
					-5Ш ажиллагааны хүрээнд Шүүр ажиллагаагаар илрүүлсэн зөрчил, тэдгээрийг арилгах талаар хэрэгжүүлсэн нэгтгэлийг хургуулав.		
3.	Арга хэмжээ1.3. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	Хувь	Тухай бүрт	100%	1.Монгол Улсын Засгийн газар, Жендерийн үндэсний хороо, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүн амын сангаас "НАДААС, ТАНААС, БИДНЭЭС ЭХЛЭЛТЭЙ" уриатайгаар зохион байгуулсан "Харицан Хүндэтгэе" үндэсний хэмжээний 1 сарын аян, "Охид, эмэгтэйчүүд хаана ч аюулгүй-Шалгал бүү тооч" уриатайгаар зохион байгуулж байгаа "Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх" 16 хоногийн аянд нийслэлийн Аялал жуулчлалын газрын хамт олон нэгдэж, аяныг сурталчилсан нийт 10 удаагийн баннер, бичлэгийг байгууллагынхаа цахим хуудсаар дамжуулан олон нийтэд түгээж 16000 гаруй хүнд хүргэсэн.	01-12-р сар	100%

					сайжруулах зорилгоор Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт сургалтад 2, Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан "Жендэр ба аялал жуулчлал" хэлэлцүүлэгт 8 албан хаагч хамрагдсан.		
4	Арга хэмжээ 1.4. Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг ханган, хүнд суртлыг багасгаж, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэн ажиллах	Хувь	Тухай бүрт	100%	"Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд: 1.Авлигаас урьдчилан сэргийлэх нөлөөллийн аянд нэгдэж "АВЛИГААС ТАТГАЛЗАХ БОЛОМЖ БИДЭНД БИЙ", "АВЛИГАД ҮГҮЙ ГЭЖ ХЭЛЦГЭЭ", авлигын эсрэг үйлдлийг "110 УТАС РУУ ҮНЭГҮЙ ЗАЛГАХ БОЛОМЖТОЙ" гэсэн 2 төрлийн баннерыг байгууллагын facedook цахим хуудсанд байршуулж 636 иргэнд, амралтын газар, жуулчны бааз, зочид буудал, дэн буудал зэрэг аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын нийт 33,300 хүний бүртгэлтэй 3 төрлийн цахим хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэж, авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн буланг сар бүр тогтмол шинэчлэн ажиллаж байна. 2.АТГ-аас гаргасан авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нийт 12 төрлийн танилцуулга, баннер, зурагт хуудсыг нийт албан	100%	

					хаагчдад танилцуулсан. Мөн плакат, брошюур, наалтыг газрын мэдээллийн салбар, хаалга, өрөө тасалгаанд байршуулж, Сүхбаатарын талбай, Төв шуудан, Хөшгийн хөндий дэх олон улсын нисэх онгоцны буудалд үйл ажиллагаа явуулдаг жуулчдын Мэдээллийн төвүүдээр дамжуулан иргэдэд тараасан. 3.Албан хаагчдыг ёс зүйн зөрчил, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 12 удаагийн сургалт, хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 67 албан хаагчийг хамруулав. 4.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд 14 албан хаагч хугацаандаа хөрөнгө орлогын мэдүүлгээ тайлагнаж, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн дүгнэлтийг үндэслэн 5 албан хаагчийг томилсон. Мөн худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороонд ажилласан 2 албан хаагчаас "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг гаргуулан цахим бүртгэлийг үүсгэж, 2 албан хаагчийн өөрчлөлтийг бүртгэлээ.		
5	Арга хэмжээ 1.5. Байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших,	Хувь	Тухай бүрт	100%	Газрын даргын нийслэлийн Өмчийн харилцааны газартай байгуулсан	01-12-р сар	100%

	ашиглах, захиран зарцуулах аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэлийг ханган ажиллах				"Нийслэлийн өмч эзэмшүүлэх гэрээ"-г шинэчлэн байгуулж, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хавсарган хүргүүлж, байгууллагын үндсэн эд хөрөнгө, бараа материалын 2024 оны тооллогыг зохион байгуулах комиссыг баталж тооллогын ажлыг зохион байгуулсан.		
Зорилт 2. "Байгууллагын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах зорилтын хүрээнд"							
6.	Арга хэмжээ 2.1. Хүний нөөцийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг байгууллагын хэмжээнд зохион байгуулах тайлагнах	Хувь	Тухай бүрт	100%	-Газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн "Ажлын байранд дүн шинжилгээ хийх, албан тушаалын тодорхойлтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай" А/12 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж, төрийн захиргааны 14, төрийн үйлчилгээний 3 нийт 17 ажлын байрны чиг үүрэгт дүн шинжилгээ хийж, Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулан, Төрийн албаны зөвлөлийн нийслэл дэх салбар зөвлөлд 13 албан тушаалын тодорхойлтыг батлуулахаар хүргүүлээд байна. -Нийслэл дэх Төрийн аудитын газраас хийсэн "Төрийн байгууллагуудын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө" сэдэвт аудитын хүрээнд 2024 оны 09-11 дүгээр сарын хооронд "Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, биелэлт, Сургалтын төлөвлөгөө, биелэлт, хүний нөөцтэй холбоотой судалгаа, холбогдох тушаал шийдвэрүүдийг нэгтгэн гаргаж өгсөн. Мөн Нийслэл дэх Төрийн	01-12-р сар	100%

				аудитын газрын хүсэлтийн дагуу Төрийн албан хаагчийн нэгдсэн судалгаа, 2012-2024 он хүртэл байгууллагын бүтэц, зохион байгуулалтын судалгаа, шийдвэрүүд, Төрийн албанд жөндөрийн тэнцвэртэй байдлыг хангаж байгаа, эсэх, Төрийн албаны хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн талаарх судалгааг нэгтгэж өгсөн. Түүнчлэн Төрийн албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллах, нийгмийн баталгаагаар хангаж байна уу, Олон нийтийн хяналтын зөвлөл ажилладаг уу, байгууллагын "Стратеги төлөвлөгөө"-ний хөтөлбөрийг баталсан уу, Хөгжлийн бодлогын баримт бичигт хүний нөөц, засаглалын бодлогыг үйл ажиллагаандаа тусгасан уу, албан тушаалын давхардал хийдлийг арилгах арга хэмжээ авсан уу, төрийн албан хаагчийн нэгдсэн тоо, бүртгэлийн мэдээллийн сан бүрдсэн үү, төрийн үйлчилгээний ил тод нээлттэй байдалд холбогдох байгууллагууд судалгаа хийсэн, эсэх зэрэг асуудлаар нэмэлт ярилцлагын тэмдэглэл гаргаж өгсөн. Тус аудитын дүгнэлт, зөвлөмжийн дүгнэлтийн дагуу хийх ажлын төлөвлөгөө гарган нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. -Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төсөл, Төрийн захиргааны албан	
--	--	--	--	---	--

					хаагчийн тангараг өргөх ёслолын журам, Төрийн албаны тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнах тухай, Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмуудын төсөлд санал тусгав. -Шинээр батлагдсан хууль, тогтоол, журмын талаарх мэдээ, мэдээллийг байгууллагын дотоод сүлжээгээр дамжуулан албан хаагчдад тогтмол хүргэж байна. -Байгууллагын цахим хуудсанд хүний нөөцийн бодлого шийдвэр болон холбогдох мэдээллийг нийтэд ил тод мэдээлэн ажилласан. -Шинээр томилогдон ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчид Төрийн албан хаагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээ, холбогдох хууль тогтоомж, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг танилцуулан ажилласан. -Албан хаагчдын төрөл бүрийн судалгааг нэгтгэн, холбогдох газруудад хүргүүлэн ажилласан.		
7.	Арга хэмжээ 2.2. Хүний нөөцийн холбогдолтой тушаал, шийдвэрийн төсөл боловсруулах, албажуулах, хэрэгжилтийг хангах	Хувь	Тухай бүрт	100%	2024 онд албан хаагчдын цалин болон хоол унааны нэмэгдлийг шинэчилсэн тушаалыг гаргасан. 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар А	01-12-р сар	100%

					тушаал 9 , Б тушаал 46-г боловсруулж, албажуулж, Хөдөлмөрийн гэрээг нийт 7 ажилтантай байгуулаад байна.		
8.	Арга хэмжээ 2.3. Төрийн албаны зөвлөлийн htm.csc.gov.mn системд байгууллагын хүний нөөцийн мэдээллийг оруулан тайлагнах.	Хувь	Тухай бүрт	100%	-“Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд Хүний нөөцийн нэгдсэн систем https://htm.csc.gov.mn/ болон нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын egr.ulaanbaatar.mn/ системд албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна. Ажлаас чөлөөлөгдсөн-6, ажилд томилогдсон-7 албан хаагчдын мэдээллийг тус тус шинэчилсэн. Мөн системийн шинэчлэлт өөрчлөлттэй холбогдуулан давхардсан тоогоор 20 гаруй албан хаагчийн мэдээллийг шинэчлэн засварласан.	01-12-р сар	100%
9.	Арга хэмжээ 2.4. Нийслэлийн албан бичиг шийдвэрлэлтийн www.edoc.ub.gov.mn програмаар албан бичиг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэх	Хувь	Тухай бүрт	100%	-2024 оны 12-р сарын 05-ны өдрийн байдлаар нийслэлийн албан бичиг шийдвэрлэлтийн www.edoc.ub.gov.mn програмаар нийт 132 албан бичиг хүлээн авч, хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн.	01-06-р сар	100%
10.	Арга хэмжээ 2.5. Төрийн албаны зөвлөлийн 600 дугаар тогтоолын хүрээнд Албан хаагчдын хувийн хэргийг журмын дагуу бүрдүүлж баяжуулах	Хувь	18 албан хаагч	100%	Шинээр орсон 6 албан хаагчийн хувийн хэргийг журмын дагуу бүрдүүлсэн.	01-12-р сар	70%
11.	Арга хэмжээ 2.6. Албан хаагчдад ажлын үр дүнг харгалзан зэрэг дэв олгуулах, цалин нэмэгдүүлэх талаар судалгаа гаргаж холбогдох албан тушаалтанд	Хувь	Тухай бүрт	100%	Ахлах түшмэл, дэд зэрэг-1, дэс түшмэл, дэд зэрэг-1, дэс түшмэл, дөтгөөр зэрэг-2 нийт 4 албан хаагчид зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгуулж 1 албан хаагчийн төрийн жинхэнэ албан хаагчийн	01-06-р сар	100%

	танилцуулж шийдвэрлүүлэх				тангарагийг өргүүлсэн.		
12.	Арга хэмжээ 2.7. Албан хаагчдын шагнал авсан байдлын судалгаа авч нэгтгэх, шаардлага хангасан албан хаагчдыг шагналд тодорхойлох	Хувь	Тухай бүрт	100%	Байгууллагын албан хаагчдын шагналын судалгааг шинэчлэн гаргасан. Өндөр насны тэтгэвэрт гарсан 1 албан хаагчийг Төрийн албаны зөвлөлөөс олгодог "Төрийн албаны тэргүүний ажилтан" цол тэмдгээр, төрийн дээд хэмжээний шагнал "Алтан гадас" одонгоор шагнуулсан. Мөн Аялал жуулчлалын өдөр, нийслэлийн өдрийг тохиолдуулан албан хаагчдыг шагнах тодорхойлтыг холбогдох газарт хүргүүлж, 1 албан хаагчийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Тэргүүний ажилтнаар, 1 албан хаагчийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Жуух бичгээр, 2 албан хаагчийг Нийслэлийн Тэргүүний ажилтнаар, 1 албан хаагчийг НИТХ-ын Хүндэт үнэмлэхээр шагнуулаад байна. 2 албан хаагчийг төрийн дээд одон медалиар шагнуулах тодорхойлт, анкетийг холбогдох газарт хүргүүлээд байна.	01-12-р сар	100%
13.	Арга хэмжээ 2.8. Албан хаагчдын ажлыг гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах	Хувь	Хагас, бүтэн жил	100%	Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлын хэсгийг байгуулж, үнэлэх ажлыг зохион байгуулж байна. 2024 оны хагас жилээр албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээ: 1.О.Нямбат /Бодлогын баримт бичгийн тайлан, сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн/ Маш сайн 99.75% 2.Б.Энхцэцэг /Аяллын бүтээгдэхүүний хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн/	01-12-р сар	100%

					Маш сайн 99.5% 3.Б.Цолмонгэрэл /Хэвлэл мэдээлэл, олон нийт хариуцсан мэргэжилтэн/ Маш сайн 98.6% 4.Ч.Энх-Отгон /Хяналт үнэлгээ, статистик судалгаа, дүн шинжилгээ хариуцсан мэргэжилтэн/ Маш сайн 98.4% 5.Ш.Ундармаа /Хүний нөөц, ёс зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтэн/ Маш сайн 96.7% 6.Б.Үржинханд /Эвент хариуцсан мэргэжилтэн/ Маш сайн 95.5% 7.Д.Долгоржав /Архив, бичиг хэргийн эрхлэгч/ Маш сайн 93.63% 8.Д.Ганболд /Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга/ Маш сайн 93.1% 9.Б.Энхтайван /Мэдээллийн технологи, цахим хөгжил хариуцсан ажилтан/ Маш сайн 93% 10.Д.Оюун-Эрдэнэ /Жуулчны аюулгүй байдал, үйлчилгээний байгууллага, стандарт хариуцсан мэргэжилтэн/ Маш сайн 92.53% 11.Д.Сайханчимэг /Гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн/ Маш сайн 92.7% 12.С.Туул /Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга/ Маш сайн 91.9% 13.Б.Мичидмаа /Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүд хариуцсан менежер/ Маш сайн 89.6% 14.Б.Отгонбилэг /Дотоодын аялал хариуцсан мэргэжилтэн/ Маш сайн 85.8% хэмээн үнэлэгдлээ.		
--	--	--	--	--	---	--	--

					Нийт 13 албан хаагчид үр дүнгийн урамшуулал олгосон. 2024 оны жилийн эцсийн Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх ажлыг зохион байгуулж байна.		
Зорилт 3. “Байгууллагын дотоод ажлын чиг үүргийг хэрэгжүүлэх, тайлагнах зорилтын хүрээнд”							
14.	Арга хэмжээ 3.1. Хүний нөөцийн чиглэлээр нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын программ www.erp.ulaanbaatar.mn -д байгууллагын мэдээлэл оруулах, тухай бүр шинэчлэх	Хувь	Тухай бүрт	100%	Сул орон тооны зар болон бүх нийтийн 2 удаагийн их цэвэрлэгээ, 1 удаагийн мод тарих арга хэмжээ, Авлига болон жендэрийн талаарх мэдээ, мэдээллийг тухай бүрт нь бэлтгэж www.erp.ulaanbaatar.mn -д нийтэлсэн.	01-12-р сар	100%
15.	Арга хэмжээ 3.2 Албан хаагчдын цаг ашиглалтад хяналт тавих, албан хаагчдын цаг ашиглалтын тайлан мэдээг сар бүр гаргах	Хувь	Сар бүр	100%	Хууль тогтоомж, байгууллагын дотоод журмын хүрээнд албан хаагчдын цагийн бүртгэлийн тайлан, тооцоог тухай бүр гаргаж, цалин, урамшуулал, ээлжийн амралт, илүү цагийн олговрыг олгож байна.	01-12-р сар	100%
16.	Арга хэмжээ 3.3 Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангаж зохион байгуулах	Хувь	Тухай бүрт	100%	Газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангаж, нийт 4 удаагийн хурлыг зохион байгуулан хурлын тэмдэглэлийг хөтөлөө.	01-12-р сар	100%

17.	Арга хэмжээ 3.4 Албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх мэдлэг олгох, мэдээллээр хангаж ажиллах /Ёс зүйн дэд хороотой хамтран хэрэгжүүлэх/	Хувь	Тухай бүрт	100%	Ёс зүйн дэд хороог байгуулж, тус хорооны 3 гишүүнд урамшуулал олгуулсан. Албан хаагчдыг ёс зүйн зөрчил, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 12 удаагийн сургалт, хэлэлцүүлэгт давхардсан тоогоор 67 албан хаагчийг хамруулаад байна. Төрийн албанд чадахуйн зарчим /мерит/-ыг тууштай хэрэгжүүлж, хоёр албан хаагчийг ахлах мэргэжилтнээр дэвшүүлэн ажиллуулж байна.	01-12-р сар	100%
18.	Арга хэмжээ 3.5 Цаг үеийн шинжтэй ажил, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, биелүүлсэн байх	Хувь	Тухай бүрт	100%	2024 онд цаг үеийн шинжтэй дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажиллалаа. 1.“Тохижилт-Бүтээн байгуулалтын жил”-ийн хүрээнд нийслэлийн Засаг даргын 2024 оны А/348 дугаар захирамжийн дагуу 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр “Хаврын их цэвэрлэгээ”-г зохион байгуулж, Сүхбаатар дүүрэг, Гадаад харилцааны яамны урд уулзвараас Төв номын сангийн хойд уулзвар хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбайн хог, хаягдлыг цэвэрлэж, модны хашлага, сандал, тамхины цэг, хогийн сав, зам дагуух сурталчилгааны самбар, гэрлийн шон, замын босоо тэмдэг, тэмдэглэгээ, дугуйн зогсоолыг угааж, цэвэрлэв. Мөн нийслэлийн Засаг даргын А/348 дугаар	01-12-р сар	100%

					захирамж, удирдамжийг аялал жуулчлалын зочлох үйлчилгээний 600 гаруй байгууллагад /зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны бааз/ албан бичгээр хүргүүлж, "Хаврын их цэвэрлэгээ"-нд нэгдэхийг уриалан ажилласан. 2.Иргэдийн эрүүл цэвэр орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хоггүй цэвэр орчныг бүрдүүлэх зорилготой "Бүх нийтийн их цэвэрлэгээ"-нд тус газрын хамт олон бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож, Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хорооны явган хүний гүүрнээс урагш 15 дугаар хорооны зааг хүртэлх Сэлбэ голын баруун талын хог хаягдлыг цэвэрлэж, нийт 30 шуудай хог хаягдлыг машин ачих боломжтой газарт бөөгнүүлэн тавьсан. Албан хаагчдыг хог цэвэрлэх багаж хэрэгсэл, шуудай, бээлийгээр хангаж, нийт 244,200 төгрөгийг зарцуулсан болно. 3.Тэрбум мод" үндэсний хөтөлбөр, бүх нийтээр мод тарих өдрийн хүрээнд "Ногоон хот-Иргэний оролцоо", "Арчлахгүй бол ургахгүй" уриалгыг тус газрын хамт олон дэмжин, ажиллаж 2024 оны 05 дугаар сарын 11-ний өдөр Налайх дүүргийн 7 дугаар хороо, "Шинэ Налайх цэцэрлэгт" хүрээлэнгийн "Жуулчин төгөл"-д мод тарьж, өмнөх жилүүдэд тарьсан моднуудынхаа		
--	--	--	--	--	--	--	--

					арчилгаа, цэнэг усалгааг хийсэн. Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Монголын аялал жуулчлалын холбоо, Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран "Жуулчин төгөл" төслийг санаачлан хэрэгжүүлж байгаа бөгөөд 2022 онд 280, 2023 онд 230, 2024 онд 86 нийт 596 ширхэг мод тариад байна. Энэ удаад тарьсан мод, сөөгний хамгаалалтын зурвас тогтоох зорилгоор хайлаас модуудыг тариад байна. 4.Нийслэлийн хүүхдийн төлөө зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд газраас хэрэгжүүлэх ажлын саналыг нэгтгэн хүргүүлэв. 5.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024 оны 04-р сарын 11-ний өдөр зохион байгуулагдсан "Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдал, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт болон нийслэлийн нутгийн захиргааны төрийн албан хаагчдын нийгмийн баталгааны бодлогыг танилцуулах" уулзалтад 15 албан хаагчийг хамруулсан. 6.2024 оны 05-р сарын 17-нд төрийн ордонд зохион байгуулагдсан "Youth mongolia" залуучуудын хөгжлийн зөвлөлийн анхдугаар чуулганд байгууллагын залуучуудын зөвлөлийн 2		
--	--	--	--	--	--	--	--

					гишүүнийг хамрууллаа. 7.2024.03.28-ны өдөр зохион байгуулагдсан Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн дадлага, сургуульд нийт 14 албан хаагчдыг хамруулав.		
--	--	--	--	--	--	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	1. "Тэнгэр" олон улсын бөөгийн арга хэмжээ зохион байгуулах	хувь	1	1	"Тэнгэр" олон улсын бөөгийн фестивалийн зохион байгуулагчдын байрлах гэрийн гэрээ байгуулах, байрлуулах ажлыг зохион байгуулж, арга хэмжээний үеэр ажлын хэсэгт орж ажилласан.	2024.05.25	100%
2.	2. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр буюу 06-р сарын 01-ний өдөр зохион байгуулсан хотын аяллын тайлан мэдээг нэгтгэн хүргэх	хувь	1	1	Нийслэлийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр баталсан "Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах ажлын хэсгийн төлөвлөгөөнд санал хүргүүлж, хэрэгжүүлсэн ажлын тайланг нэгтгэж, нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт хүргүүлсэн	2024.06.04	100%
3.	"Даншиг" наадам зохион байгуулах	хувь	1	1	Арга хэмжээний ажлын хэсэгт орж, лам нарын дунд зохион байгуулсан	2024.08.03-04	100%

					балин урлал, ном хаялцах, унзат хоолойтой лам нарын тэмцээний зохион байгуулалтыг хариуцан ажилласан.		
4.	"UB FOOD" фестиваль зохион байгуулах тухай	хувь	1	1	Арга хэмжээний ажлын хэсэгт орж төв тайзны хөтөлбөр, тоглолт, шилдэг тогооч нарын шалгаруулалт болон бусад зохион байгуулалтад орж ажилласан.	2024.08.23-25	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Хариуцсан асуудлын хүрээнд шинэчлэн гарсан хууль, дүрэм, журмыг судлах.	-	4	2	Хариуцсан ажлынхаа хүрээнд Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг уншиж судалсан. Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төсөл, Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам, Төрийн албаны тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнах тухай, Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмуудын төсөлд санал тусгасан.	01-12-р сар	100%
2.	Арга хэмжээ 2. Хариуцсан асуудлын хүрээнд мэдлэг, мэдээллээ сайжруулах сургалтад	-	4	2	Нийт 8 төрлийн сургалтад хамрагдсан. Тухайлбал, 1."Өргөдөл гомдлын системийн	01-12-р сар	100%

хамрагдсан байна.			хэрэглээ" 2."Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн хэрэглээ-Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль" 3."Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт" 4."Хүний нөөцийн удирдлага", АТГ- аас зохион байгуулсан ЭБАТ-д зориулсан цахим сургалт 2 удаагийн сургалт 5.Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалт 6.Мега хотын засаглалын шинэчлэл цахим сургалт 7.Төрийн албан хаагчийг чадавжуулах хүний нөөцийн удирдлага сургалт 8.Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг /7-4-10/ сургалтад 16 удаа суусан байна.		
-------------------	--	--	---	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХҮНИЙ НӨӨЦ,ЁС ЗҮЙ ДОТООД
АЖИЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
(Албан тушаал)

Ш.УНДАРМАА / *Ш. Ундармаа* /
(Нэр, гарын үсэг)

2024.06.10
(Огноо)